



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА-2018

2019 ОН

Агуулга

Оршил

Нэг. Ойлголт, тодорхойлолт

Хоёр. Аж үйлдвэрийн салбар

Гурав. Барилгын салбар

Дөрөв. Худалдааны салбар

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт2.1 Бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо, салбараар

Хүснэгт2.2 Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо, салбараар, ажиллагчдын тооны бүлгээр

Хүснэгт2.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, сумаар, 2015-2018 он

Хүснэгт2.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, салбар, дэд салбар, дүнд эзлэх хувиар

Хүснэгт2.5 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр

Хүснэгт2.6 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, оны үнээр, тэрбум төгрөг

Хүснэгт2.7 Аж үйлдвэрийн салбарын мэдээнд хамрагдсан аж ахуй нэгж иргэдийн тоо

Хүснэгт2.8 Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо, 2014-2018 он

Хүснэгт2.9 Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж, салбар, дэд салбараар, мянган төгрөг

Хүснэгт3.1 Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр, сая төгрөг

Хүснэгт3.2 Ашиглалтанд оруулсан орон сууцанд амьдарч буй өрх, хүн амын тоо

Хүснэгт4.1 Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо, 2014-2018 оноор

Хүснэгт4.2 Худалдааны нийт борлуулалт, аймаг, бүсээр, 2016-2018 он

Зургийн жагсаалт

Зураг2.1 Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо, ажиллагчдын тооны бүлгээр, дүнд эзлэх хувь

Зураг2.2 Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, сая төгрөгөөр, 2010-2018 он

Зураг2.3 Нийт бүтээгдэхүүн борлуулалт, сая төгрөгөөр, 2010-2018 он

Зураг2.4 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, хувиар, 2010-2018 он

Зураг2.5 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, аж ахуй нэгжийн хэлбэрээр, хувиар, 2018 он

Зураг3.1 Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо, жил бүрийн эцэст

Зураг3.2 Барилгын салбарын нэмэгдэл өртөг, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, сая төгрөгөөр

Зураг3.3 Барилга, угсралт их засварын ажил, төрлөөр, мян төг

ЗУРАГ3.4 Ашиглалтагд оруулсан орон сууцанд амьдарч буй өрх, хүн амын тоо

Зураг4.1 Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагын тоо, байгууллагын бүтэц, ажиллагчдын тооны бүлгээр

Зураг4.2 Худалдааны салбарт ажиллагчдын тоо

Дүгнэлт

ОРШИЛ

Газар зүйн байрлалын хувьд эх орны өмнөд хязгаарт 109,4 мян.км² нутгийг эзлэн, урд талаараа БНХАУ-тай баруун, хойд, зүүн талаараа Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хиллэн оршино. Аймгийн нутаг бүхэлдээ говийн бүсэд багтдаг боловч нутгийн өмнөд хэсэг нь говь, хойд хэсэг нь говь хээр хосолсон нутаг юм.

Дорноговь аймгийн бүх сумд цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон бөгөөд үйл ажиллагааг Чойрын ЦТСС, УБТЗ-ын ЭХУХ-ийн 2-р анги, Дорноговь ЦСС-ууд тус тус хариуцан ажиллаж байна.

Тус аймагт 1940 оны дунд үеэс анхны үйлдвэрүүдийн суурь тавигдсан бөгөөд гар үйлдвэрийн артель, хүнсний үйлдвэр, хэвлэх үйлдвэр эхлэн байгуулагдсан юм. 1960-1980 онуудад мод боловсруулах үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр, нэгдэл дундын үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, уулын баяжуулах үйлдвэрүүд байгуулагдсан бөгөөд 1980-аад оны дунд үеэс карьер боловсруулах үйлдвэр, хүнсний бусад үйлдвэрүүд байгуулагдсан билээ.

Зах зээлийн эдийн засагт шилжсэн 1994 оны дунд үеэс тус аймагт жижиг үйлдвэр эрхлэх идэвхи, санаачилга эрс нэмэгдсэн билээ. 1991, 1992 онд улсын үйлдвэр байсан мод, ахуйн үйлчилгээний чиглэлийн үйлдвэрүүд хувьчлагдан, хэд хэдэн жижиг үйлдвэр байгуулагдсан юм. Тухайлбал: 1992 онд ахуйн үйлчилгээний чиглэлийн жижиг үйлдвэр Айраг суманд 2, Даланжаргалан суманд 1, Дэлгэрэх суманд 2, Иххэт суманд 1, Мандах суманд 1, Хатанбулаг суманд 1, Хөвсгөл суманд 1, Сайншанд суманд 3 тус тус ажиллаж байжээ.

Сүүлийн жилүүдэд Даланжаргалан, Өргөн сумдад цементийн цогц үйлдвэр ашиглалтанд орсон. Тус үйлдвэрүүд нь хоногт 3500 тонн клинкер болон жилд 1 сая тонн өндөр чанарын цемент үйлдвэрлэх хүчин чадалтай евро стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн гаргах боломжтой.

Монголын хамгийн том гэгдэх 55мВт суурилагдсан хүчин чадал бүхий салхин парк ашиглалтанд орж, жилд 100 мянга гаруй айл өрхийн цахилгаан хэрэглээг хангахуйц ногоон эрчим хүч үйлдвэрлэн 200 мянга гаран тонн нүүрс хүчлийн хий агаар мандалд ялгарахаас сэргийлэх юм. Мөн Алтанширээ суманд газрын тос боловсруулах үйлдвэр баригдаж байгаа бөгөөд бүтээн байгуулалтын ажлын явцад 1200-1500 ажлын байр, үйлдвэр ашиглалтанд орсноор 600 хүн байнгын ажлын байртай болох юм.

Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь өөрсдөө үйлдвэрлэл явуулахгүй боловч үйлдвэрлэгчээс бараа, материал худалдан авч, ямар нэг нэмэлт боловсруулалт хийлгүйгээр дахин худалддаг онцлогтой салбар юм. Худалдааны байгууллагууд ихэнхдээ бөөний болон жижиглэн худалдаа дагнах эсвэл холимог хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

Бөөний худалдаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эсвэл дараагийн шатны худалдаанд зориулан бөөнөөр борлуулах үйл ажиллагааг хамруулдаг бол харин жижиглэн худалдаанд хүн амын хэрэгцээнд зориулсан өргөн хэрэглээний бараа,

бүтээгдэхүүнд дахин боловсруулалт хийлгүй эцсийн хэрэглэгчид хүргэх үйл ажиллагаа багтдаг. “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал” 4.0-ын дагуу дотоод худалдааны салбар дараах 3 дэд салбараас бүрддэг. Үүнд:

Машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ дэд салбарт шинэ болон хуучин автомашин мотоциклийн бөөний болон жижиглэнгийн худалдаа, техникийн засвар үйлчилгээ, сэлбэг шатахууны жижиглэн худалдаа (код 45),

Машин, мотоциклоос бусад барааны бөөний болон комиссын худалдаа дэд салбарт жижиглэн худалдаа, үйлдвэр, байгууллагын хэрэгцээнд барааг бөөнөөр нийлүүлдэг байгууллага, экспорт, импорт эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа (код 46),

Машин, мотоциклоос бусад барааны жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ дэд салбарт хүн ам, гэр ахуйн хэрэгцээнд зориулан дэлгүүр, лангуу, үүргийн болон захиалга, дуудлагаар бараа худалдах үйл ажиллагаа (код 47) зэрэг багтана. Дотоод худалдааны салбарын хамрах хүрээг албан болон албан бус гэж 2 хуваан авч үзэж ДНБ-ий тооцоонд тусгаж байна.

Албан секторын хамрах хүрээ нь бизнес регистрийн санд бүртгэлтэй бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт болно. Албан бус секторын үйл ажиллагаанд албан ёсоор аж ахуйн нэгж, байгууллага гэж бүртгэгдээгүй, патентын зөвшөөрөлтэй хувиараа худалдаа эрхлэгчдийг оруулж байна. Эдгээрт лангуу, чингэлгийн худалдаа, түргэн үйлчилгээний цэгүүд, гутал засвар, авто засварын үйл ажиллагаанууд орж байна.

НЭГ.ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Аж үйлдвэрийн салбар

| Ойлголт | Тодорхойлолт |
|--|---|
| Нийт үйлдвэрлэл | Тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ |
| Завсрын хэрэглээ | Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орц болж зарцуулагдсан бүтээгдэхүүний зардал (худалдан авсан барааны өртгөөс жилийн эцсийн нөөцийн өөрчлөлтийг хасна) болон үйлчилгээний төлбөрийг хэлнэ. |
| Нэмэгдэл өртөг | Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хассан дүнг хэлнэ. Нийт үйлдвэрлэлийн үндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ. |
| Бүтээгдэхүүний борлуулалт | Тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ. |
| Аж үйлдвэрийн борлуулалт | Зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй. |
| Үндсэн үнэ | Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно. |
| Үйлдвэрлэгчийн үнэ | Үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татвар (нэмэгдсэн өртгийн татвараас бусад) болон тээвэр, худалдааны нэмэгдлүүдийг нэмж, татаасыг хасаж тооцсон үнийг хэлнэ. |
| Зах зээлийн үнэ буюу худалдан авагчийн үнэ | Үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг хэлнэ. |
| Бүтээгдэхүүн | Үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ. |
| Хагас боловсруулсан бүтээгдэхүүн | Зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ. |

| | |
|-----------------------------------|--|
| (дуусаагүй үйлдвэрлэл) | |
| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн | Тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ. |
| Ажиллагч | Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Ажил эрхлэлттэй холбоотой ойлголт, тодорхойлолт нь хөдөлмөрийн статистикт ашигладаг ойлголт, тодорхойлолттой адил байна. |
| Ажилласан цаг | Тайлант хугацаанд ажиллагчид (цалин хөлстэй ажиллагч болон цалин хөлсгүй ажиллагч)-ийн ажилласан цагийг хэлнэ. |
| Барилгын салбар | |
| Объект | Бие даасан барилга (орон сууц, үйлдвэрийн гол корпус, сургууль, цех, агуулах) буюу байгууламж (зам, гүүр, далан, суваг, нүхэн гарц) түүнтэй холбогдож хийгдэх үндсэн ба туслах чанарын бусад байгууламж, гадна инженерийн бүх төрлийн шугам сүлжээ, хийц тоноглол, барилгын талбайд хийгдэх өндөржилт, тохижилтын бүх ажил |
| Барилга байгууламж | Олон төрлийн зориулалтаар шинээр буюу өргөтгөл, шинэчлэл хийх, нэгдсэн зураг төслөөр баригдах байгууламж |
| Барилга угсралт, их засварын ажил | Барилга, байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагаа |
| Орон сууцны барилга | Хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж |
| Орон сууцны бус барилга | Барилгын багахан хэсг ийг (Нийт талбайн 50 хувиас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна. |
| Инженерийн барилга, байгууламж | Төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, усан хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга, байгууламжийн бүх ажил |

ХОЁР. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар 1597 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 1161 аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо өмнөх оноос 158(11.0%)-аар, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 19(1.7%)-өөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, салбараар

| Салбарын ангилал | 2015 | 2016 | 2017 | 2018 | Үүнээс: Үйл ажиллагаа явуулж байгаа |
|--|-------------|-------------|-------------|-------------|---|
| БҮГД | 1181 | 1298 | 1439 | 1597 | 1161 |
| Хөдөө аж ахуй | 34 | 39 | 43 | 54 | 37 |
| Олборлох үйлдвэр | 15 | 17 | 18 | 35 | 14 |
| Боловсруулах аж үйлдвэр | 49 | 52 | 63 | 73 | 48 |
| Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж | 1 | 2 | 2 | 2 | 2 |
| Бохир ус, хог хаягдлын менежментийн болон цэвэрлэх үйл ажиллагаа | 6 | 6 | 6 | 7 | 7 |
| Барилга | 37 | 45 | 52 | 68 | 55 |
| Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн, барааны засварлах үйл ажиллагаа | 330 | 352 | 397 | 430 | 314 |
| Тээвэр агуулахын аж ахуй, холбоо | 54 | 61 | 72 | 87 | 53 |
| Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | 77 | 78 | 87 | 95 | 72 |
| Мэдээлэл холбоо | 27 | 25 | 29 | 28 | 18 |
| Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа | 82 | 91 | 93 | 95 | 60 |
| Үл хөдлөх хөрөнгө, түрээс бизнесийн үйл ажиллагаа | 22 | 25 | 22 | 23 | 23 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 43 | 44 | 47 | 60 | 39 |
| Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 19 | 24 | 30 | 34 | 25 |
| Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал | 62 | 63 | 65 | 66 | 66 |
| Боловсролын салбарын үйл ажиллагаа | 76 | 78 | 81 | 86 | 72 |
| Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 37 | 41 | 41 | 41 | 38 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 27 | 28 | 33 | 34 | 31 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 183 | 227 | 258 | 279 | 187 |


2018 онд үйл ажиллагаа явуулж байгаа 1169 аж ахуйн нэгжээс аж үйлдвэрийн салбар буюу уул уурхайн олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэр, цахилгаан хий үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 110 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ2.2 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, салбараар, ажиллагчдын тооны бүлгээр

| Салбарын ангилал | 2018 | Ажиллагчдын тооны бүлэг | | | |
|--|-------------|-------------------------|------------|-----------|-----------|
| | | 1-9 | 10-19. | 20-49 | 50+ |
| БҮГД | 1161 | 935 | 103 | 90 | 33 |
| Хөдөө аж ахуй | 37 | 33 | 4 | | |
| Олборлох үйлдвэр | 14 | 13 | | | 1 |
| Боловсруулах аж үйлдвэр | 48 | 44 | 3 | 1 | |
| Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж | 2 | | | | 2 |
| Бохир ус, хог хаягдлын менежментийн болон цэвэрлэх үйл ажиллагаа | 7 | 5 | | 1 | 1 |
| Барилга | 56 | 40 | 7 | 7 | 2 |
| Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн, барааны засварлах үйл ажиллагаа | 314 | 300 | 9 | 2 | 3 |
| Тээвэр агуулахын аж ахуй, холбоо | 53 | 44 | 2 | 4 | 3 |
| Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | 72 | 61 | 9 | 2 | |
| Мэдээлэл холбоо | 18 | 16 | 2 | | |
| Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа | 60 | 59 | | 1 | |
| Үл хөдлөх хөрөнгө, түрээс бизнесийн үйл ажиллагаа | 23 | 23 | | | |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 39 | 32 | 4 | 2 | 1 |
| Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 25 | 20 | 4 | 1 | |
| Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал | 66 | 29 | 8 | 22 | 7 |
| Боловсролын салбарын үйл ажиллагаа | 72 | 19 | 16 | 27 | 10 |
| Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 38 | 11 | 18 | 8 | 1 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 31 | 26 | 4 | | 1 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 186 | 160 | 13 | 12 | 1 |

Үйл ажиллагаа явуулж буй 1161 аж ахуйн нэгж байгууллагын 935 нь 1-9 ажиллагчтай, 103 нь 10-19 ажиллагчтай, 90 нь 20-49 ажиллагчтай, 33 нь 50-аас дээш ажиллагчтай үйл ажиллагаа явуулж байна.


ЗУРАГ 2.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, ажиллагчдын тооны бүлгээр, дүнд эзлэх хувь



2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 1161 аж ахуй нэгж байгууллага үйл явуулж байгаа бөгөөд 1-9 ажилчидтай аж ахуй нэгж 80.5 хувь, 10-19 ажилчидтай аж ахуй нэгж 8.9 хувь, 20-49 ажилчидтай аж ахуй нэгж 7.8 хувь, 50-аас дээш ажилчидтай аж ахуй нэгж 2.8 хувийг тус тус эзэлж байна.


2018 оны жилийн эцсийн байдлаар Дорноговь аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 230744.1 сая төгрөгт хүрчээ.

ЗУРАГ 2.2 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөгөөр, 2010-2018 он



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс 68492.0 (42.2%) сая төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 2.3 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, сая төгрөгөөр, 2010-2018 он



Аж үйлдвэрийн салбарт 2018 оны жилийн эцсийн байдлаар 339177.4 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод гадаад зах зээлд борлуулжээ.


Нийт борлуулалт өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар өссөн байна. Үйлдвэрлэл, борлуулалтын өсөлтөнд уул уурхай, боловсруулах аж үйлдвэрлэлийн салбаруудад шинээр үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуй нэгжүүд нэмэгдсэн нь нөлөөлж байна.

ЗУРАГ2.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТИЙН БҮТЭЦ, салбараар, хувиар, 2010-2018 он



Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 56.0 хувийг уул, уурхай олборлох үйлдвэрлэл, 40.0 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 4.0 хувийг цахилгаан, дулаан, эрчим хүч, усан хангамж үйлдвэрлэлийн салбар эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад уул, уурхай олборлох үйлдвэрлэл 4.7 пунктээр нэмэгдэж, боловсруулах үйлдвэрлэл 4.5 пунктээр, цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж 2.0 пунктээр тус тус буурчээ.

ЗУРАГ2.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, аж ахуй нэгжийн хэлбэрээр, хувиар, 2018 он



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 4.0 хувийг улсын үйлдвэрийн газар, 95.5 хувийг компани, өрхийн аж ахуй 0.4 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ2.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, сумаар, 2015-2018 он

| | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---------------|----------------|----------------|-----------------|-----------------|
| Дүн | 10509.4 | 35998.5 | 162252.1 | 230744.1 |
| Айраг | 17.7 | 31.4 | 23.8 | 23.1 |
| Алтанширээ | 28.5 | 15.8 | 10.3 | 33.2 |
| Даланжаргалан | 1251.6 | 8546.4 | 28796.4 | 92203.2 |
| Дэлгэрэх | 24.4 | 5.9 | 6.4 | 2 |
| Иххэт | 21.1 | 11.6 | 16.7 | 12.1 |
| Мандах | 42.2 | 47.2 | 19.97 | 12325 |
| Өргөн | 12.5 | 9892.5 | 24223.8 | 28343.4 |
| Сайхандулаан | 6.4 | 0.8 | 0.4 | 5 |
| Улаанбадрах | 10.4 | 6.7 | 4.4 | 81.6 |
| Хатанбулаг | 75.7 | 31.0 | 9.8 | 4.8 |
| Хөвсгөл | 33.2 | 6014.0 | 68443.4 | 85346.9 |
| Эрдэнэ | 14.9 | 10.8 | 9.9 | 5.4 |
| Сайншанд | 6593.2 | 8986.1 | 38109.8 | 9384.1 |
| Замын-Үүд | 2377.5 | 2398.2116 | 2577 | 2974.3 |

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг дэд салбарын дүнд эзлэх хувир тооцож үзэхэд уул, уурхай олборлох аж үйлдвэрийн салбарын эзлэх нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн дүнд 51.3 хувийг эзж байгаа нь өмнөх оны мөн үеэс 10.6 пунктээр өсчээ.

ХҮСНЭГТ2.4 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбар, дэд салбар, дүнд эзлэх хувиар

| Салбар | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|--------------|--------------|--------------|--------------|
| Дүн | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Уул уурхай олборлох аж үйлдвэр | 16.6 | 40.7 | 51.3 | 56.0 |
| Нүүрс олборлолт | 13.9 | 40.7 | 51.3 | 56.0 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 2.7 | 0 | 0 | 0.0 |
| Боловсруулах аж үйлдвэр | 13.5 | 34.5 | 44.6 | 40.0 |
| Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 7.4 | 5.7 | 20.5 | 0.5 |
| мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 0.4 | 3.8 | 20.0 | 0.1 |
| сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 0.7 | 0.3 | 0.1 | 0.1 |
| хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 6.2 | 1.6 | 0.4 | 0.3 |
| Хувцас үйлдвэрлэл | 0.6 | 0.2 | 0.0 | 0.0 |
| Гутал үйлдвэрлэл | 0.1 | 0 | 0.0 | 0.0 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 0.4 | 0.1 | 0.0 | 0.0 |
| Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр | 0 | 0 | 0 | 0 |
| Боловсруулах үйлдвэрийн бусад | 5 | 28.5 | 24.1 | 39.4 |
| Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж | 69.9 | 24.8 | 4.1 | 4.0 |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл | 56.6 | 20.1 | 2.9 | 2.9 |
| Ус ариутгал, усан хангамж | 13.3 | 4.7 | 1.2 | 1.1 |

ХҮСНЭГТ2.5 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр

| | Хэмжих нэгж | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2018 2017 |
|-------------------|-------------|---------|---------|---------|---------|---------|--------------|
| Цахилгаан | мян.квт.ц | 443.8 | 359.8 | 307.1 | 123.3 | 0 | 0.0 |
| Дулаан | мян.ккал | 68.9 | 80 | 110.5 | 111.6 | 120.7 | 108.2 |
| Төмрийн хүдэр | мян.тн | 4.6 | 36.4 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Хайрга | мян.м3 | 37.1 | | 17.4 | 8.7 | 23.9 | 274.7 |
| Талх | тн | 83.0 | 160.5 | 112.33 | 142.4 | 125.8 | 88.3 |
| Нарийн боов | тн | 51.0 | 71.3 | 62.6 | 56.8 | 81.8 | 144.0 |
| Бялуу | тн | 1.75 | 3.00 | 2.2 | 3.3 | 4.5 | 136.4 |
| Архи | мян.л | | | | | | 0.0 |
| Хиам | тн | 7.8 | 8.4 | 8.3 | 8.9 | 9.6 | 107.9 |
| Зайрмаг | мян.шир | 5.8 | | 0.8 | | | |
| Модон эдлэл | мян.төг | 19146.0 | 40043.0 | 38977.7 | 51954.6 | 95122.0 | 183.1 |
| Жижиг төмөр эдлэл | мян.төг | 1334.5 | 4933.0 | 745.0 | 822.0 | 560.0 | 68.1 |
| Дээл тэрлэг | шир | 442 | 499 | 416 | 221 | 374 | 169.2 |
| Цонх | м2 | 2870.9 | 1264.6 | 1377.3 | 1875.6 | 2196.8 | 117.1 |
| Оёдол | мян.төг | 36227.4 | 38798.8 | 33279.8 | 17860.2 | 44477.0 | 2.51 |
| Нүүрс | мян.тн | 103.0 | 6.2 | 418.8 | 1455.9 | 1624.8 | 111.6 |
| Блок | мян.шир | 82.9 | | 49.3 | 23.9 | 7.1 | 29.7 |
| Тоосго | сая.ш | 1.4 | | | | | |
| Бетон зуурмаг | м3 | 3687 | | 362.2 | 3951.5 | 10969.9 | 2.81 |
| Савласан цэвэр ус | мян.л | 2533.6 | 3096.1 | 2651.4 | 2328.9 | 2017.2 | 86.6 |
| Сувагжуулалт | мян.м3 | 414.1 | 491 | 601.3 | 348.4 | 668.7 | 191.9 |
| Ус түгээлт | мян.м3 | 673.3 | 671.8 | 810.8 | 784.6 | 886.6 | 113.0 |
| Цемент | мян.тн | | | 83.1 | 285.7 | 603.9 | 2.11 |

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өмнөх оны мөн үетэй харьцуулахад, дулаан 9.1 мян.ккал-аар, хайрга 15.2 мян.м3-ээр, нарийн боов 25.0 тонноор, бялуу 1.2 тонноор, хиам 1.3 тонноор, модон эдлэл 43167.4 мян.төгрөгөөр, дээл 153 ширхгээр, вакуум цонх 321.2 м2-аар, оёдол 26616.8 мян.төгрөгөөр, нүүрс 168.9 мян.тонноор, бетон зуурмаг 7018.4 м3-ээр, ус түгээлт 102.0 мян.м3-аар, сувагжуулалт 91.2 мян.м3-аар, ус түгээлт 102.0 мян.м3-ээр, цемент 318.2 мян.тн-оор тус тус илүү үйлдвэрлэгджээ.

ХҮСНЭГТ2.6 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, оны үнээр, тэрбум төг

| | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|------------------------|---------|---------|---------|---------|---------|
| Улсын дүн | 11137.8 | 10032.1 | 11083.5 | 15154.4 | 18297.5 |
| Төвийн бүс | 1188.3 | 937.4 | 1508.9 | 3069.5 | 3886.9 |
| Дорноговь аймаг | 12.7 | 12.1 | 55.6 | 273.5 | 339.2 |
| Улсын дүнд эзлэх хувь | 0.1 | 0.1 | 0.5 | 1.8 | 1.9 |
| Бүсийн дүнд эзлэх хувь | 1.1 | 1.3 | 3.7 | 8.9 | 8.7 |

Дорноговь аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалт нь 2018 онд улсын дүнд 1.9 хувь, бүсийн дүнд 8.7 хувийг тус тус эзэлж байна. Бүтээгдэхүүний борлуулалтын улсын дүнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр өсч, бүсийн дүнд эзлэх хувь 0.2 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ2.7 АЖ ҮЙЛДВЭРИЙН МЭДЭЭНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН ТОО

| Салбар | ААН | ИРГЭН |
|---|-----------|-----------|
| Дүн | 42 | 69 |
| Уул уурхай олборлох аж үйлдвэр | 4 | 0 |
| Нүүрс олборлолт | 4 | |
| Бусад ашигт малтмал олборлолт | | |
| Боловсруулах аж үйлдвэр | 36 | 69 |
| Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 18 | 38 |
| мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 2 | |
| сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 1 | 1 |
| хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 15 | 37 |
| Хувцас үйлдвэрлэл | 1 | 15 |
| Гутал үйлдвэрлэл | | 2 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 1 | 5 |
| Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл | | 2 |
| Боловсруулах үйлдвэрийн бусад | 16 | 7 |
| Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж | 2 | 0 |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл | 2 | |
| Ус ариутгал, усан хангамж | | |

Сар бүрийн аж үйлдвэрийн салбарын мэдээнд нийт 111 нэгж хамрагдсанаас 69 нь өрхийн аж ахуй эрхэлсэн иргэд байна. 2018 онд боловсруулах аж үйлдвэрийн салбарт 2, уул уурхай олборлолтын салбарт 1 аж ахуй нэгж, гутал үйлдвэрлэл 1, оёдол-1, талх нарийн боов үйлдвэрлэл-3 иргэн тус тус шинээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ2.8 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО

| Салбар | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2018 2017 |
|--------------------------------------|-------------|------------|-------------|-------------|-------------|------------------|
| Бүгд | 1095 | 841 | 1142 | 1436 | 1685 | 117.3 |
| Олборлох үйлдвэр | 459 | 170 | 269 | 144 | 480 | 3.3 ² |
| Боловсруулах үйлдвэр | 201 | 309 | 474 | 948 | 822 | 86.7 |
| Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж | 435 | 362 | 399 | 344 | 383 | 111.3 |

Аж үйлдвэрийн салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын ажиллагчдын тоо өмнөх оноос 17.3 хувиар өссөн байна. Салбараар авч үзвэл олборлох аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо 3 дахин, цахилгаан хий үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын ажиллагчдын тоо 11.3 хувиар өсч, боловсруулах салбарын ажиллагчид 13.3 хувиар буурчээ.

Аж үйлдвэрийн салбарын 2018 оны хөдөлмөрийн бүтээмж нь 2017 оноос 26.2 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ2.9 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, салбар, дэд салбараар, мян төг

| Салбар | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|-------------|-------------|--------------|--------------|
| Дүн | 12.5 | 29.8 | 107.4 | 126.2 |
| Уул уурхай олборлох аж үйлдвэр | 9.7 | 54.5 | 645.4 | 222.6 |
| Нүүрс олборлолт | 27.5 | 54.5 | 645.4 | 222.6 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 3.3 | | | |
| Боловсруулах аж үйлдвэр | 4.7 | 23.3 | 113.7 | 106.6 |
| Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 5.4 | 11.6 | 209.20 | 7.6 |
| Хувцас үйлдвэрлэл | 1.6 | 3.0 | 4.8 | 3.4 |
| Гутал үйлдвэрлэл | 3.2 | 5.4 | 4.7 | 13.4 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 3.6 | 3.6 | 5.8 | 15.9 |
| Машин тоног төхөөрөмжөөс бусад жижиг төмөр эдлэл үйлдвэрлэл | 5.2 | 0.7 | 0.4 | 0.4 |
| Боловсруулах үйлдвэрийн бусад | 5.4 | 32.1 | 86 | 133.5 |
| Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж | 20.5 | 22 | 22.9 | 24.3 |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл | 22.2 | 33.4 | 29.8 | 32.0 |
| Ус ариутгал, усан хангамж | 15.5 | 8.9 | 14.6 | 15.0 |

ГУРАВ. БАРИЛГЫН САЛБАР

Барилгын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)-ын дагуу барилга угсралт, иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа, барилгын тусгай үйл ажиллагаа гэсэн 3 дэд салбарын ажиллагааг хамруулан авч үздэг.

Бизнес регистрийн санд 2018 оны эцэст нийт 1597 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 68 буюу 4.3 хувь нь барилгын салбарт хамаарч байна. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын дүнд барилгын салбарт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь өмнөх оноос 0.7 пунктээр нэмэгдсэн байна.

ЗУРАГ3.1 БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, жил бүрийн эцэст



Барилгын салбарт бүртгэлтэй 68 ААНБ-аас 55 буюу 80.9 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 15 ААНБ буюу 0.7 хувиар нэмэгдсэн байна.

Тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо тасралтгүй өссөн нь төрөөс ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй зээл, барилгын материалын үнэ, орон сууцны үнэ тогтворжуулах хөтөлбөр гэх мэт хүн амыг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн ДНБ-ий хэмжээ 2018 оны гүйцэтгэлээр 349.6 тэрбум төгрөгт хүрсний 7.9 тэрбум төгрөг буюу 2.3 хувийг барилгын салбар бүрдүүлж байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 7.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 1.7 тэрбум төгрөг буюу 27.4 хувиар нэмэгдсэн байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2018 онд 2.3 хувь байгаа нь өмнөх оноос 0.2 пунктээр өссөн байна.

ЗУРАГ3.2 БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, сая төгрөгөөр



2018 онд нийт 423234.8 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 1.7 хувийг улсын төсвийн, 1.6 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

ХҮСНЭГТ3.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, оны үнээр, сая төгрөг

| | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|------------------------|-----------|-----------|----------|---------|-----------|
| Улсын дүн | 2146796.3 | 2290540.3 | 2482407 | 3130661 | 4009817.5 |
| Төвийн бүс | 385925.2 | 317761.1 | 176338.4 | 662848 | 1417255 |
| Дорноговь аймаг | 115802.4 | 28878.8 | 17046.2 | 111924 | 423234.8 |
| Улсын дүнд эзлэх хувь | 5.4 | 1.3 | 0.7 | 3.6 | 10.6 |
| Бүсийн дүнд эзлэх хувь | 30 | 9.2 | 9.7 | 16.9 | 29.9 |

Барилга угсралт их засварын ажлын 4.8 хувь нь орон сууцны барилга, 16.5 хувь нь орон сууцны бус барилга, 77.8 хувь нь инженерийн барилга, байгууламж, 1.0 хувь нь их засварын ажил байна.

Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны барилгын эзлэх хувь 16.7 пунктээр, орон сууцны бус барилгын эзлэх хувь 16.2 пунктээр, их засварын ажлын эзлэх хувь 1.6 пунктээр буурч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 34.6 пунктээр өссөн байна.


ЗУРАГ3.3 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, мян төг



ХҮСНЭГТ3.2 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, м2, оны эцэст

| | | Хэмжих нэгж | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2018 / 2017 |
|---------------|--------|-------------|---------|--------|---------|---------|-------------|
| Нийт талбай | | м2 | 17483.8 | 6453.0 | 18696.5 | 19666.6 | 105.2 |
| өмчийн хэлбэр | Төрийн | м2 | 104.0 | | 126.0 | | |
| | Хувийн | м2 | 17379.8 | 6453.0 | 18570.5 | 19666.6 | 105.9 |
| Сууцны талбай | | м2 | 13599.3 | 5616.0 | 14792.5 | 15790.4 | 106.7 |
| өмчийн хэлбэр | Төрийн | м2 | 64.0 | | 116.0 | | |
| | Хувийн | м2 | 13535.3 | 5615.0 | 14676.5 | 15790.4 | 107.6 |

ЗУРАГ3.4 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦАНД АМЬДАРЧ БУЙ өрх, хүн амын тоо



ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГТ ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

1. Худалдааны салбарын эдийн засгийн өсөлт

Бизнес регистрийн санд 2018 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй нийт 1161 аж ахуйн нэгж, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн 430 аж ахуйн нэгж буюу 37.0 хувь нь худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллага байна.

ХҮСНЭГТ4.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО 2014-2018 оноор

| | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|-------------|-------------|-------------|-------------|-------------|
| ААНБ-ын тоо-Бүгд | 1088 | 1181 | 1298 | 1439 | 1597 |
| Үйл ажиллагаа явуулж буй ААН байгууллагын тоо | 841 | 922 | 1002 | 1069 | 1161 |
| Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо | 280 | 330 | 352 | 397 | 430 |
| Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн эзлэх хувь | 33.3 | 35.8 | 35.1 | 37.1 | 37.0 |


Аймгийн хэмжээнд худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 2018 онд 430 болж өмнөх оны мөн үеэс 33 буюу 8.3 хувиар өсч, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын дүнд эзлэх хувиар авч үзвэл 2018 онд 37.0 хувь болж, 2014 оноос 3.7 хувиар өссөн байна. Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгджээ.

ЗУРАГ4.1 ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ажиллагчдын тооны бүлгээр



Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын 95.5 хувийг 1-9 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага, 10-19 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 2.9 хувийг, 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 1.0 хувийг эзэлж, үлдэх 0.6 хувийг 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага бүрдүүлж байна.

ЗУРАГ4.2 ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО



Худалдааны салбарт ажиллагчдын тоо 2018 онд 314 болж өмнөх оноос 6.1 хувиар, 2014 оноос 42.7 хувиар тус тус өсчээ. Сүүлийн жилүүдэд тасралтгүй нэмэгдэж, жилд дунджаар 19 хүнээр нэмэгдэж байна.

ХҮСНЭГТ4.2 ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, аймаг, бүсээр, 2016-2018 он

| Аймаг | 2016 | 2017 | 2018 | 2018 2017 | 2018 2016 |
|------------------|-----------------|-----------------|------------------|--------------|--------------|
| Дорноговь | 57,129.4 | 59,675.2 | 116,112.3 | 194.6 | 203.2 |
| Дундговь | 25,547.6 | 25,018.6 | 39,951.2 | 159.7 | 156.4 |
| Өмнөговь | 86,628.6 | 117,812.9 | 135,307.4 | 114.8 | 156.2 |
| Сэлэнгэ | 19,641.1 | 21,997.0 | 42,123.0 | 191.5 | 214.5 |
| Төв | 15,949.4 | 21,804.2 | 15,191.8 | 69.7 | 95.2 |
| Дархан-Уул | 122,198.7 | 148,504.5 | 219,962.7 | 148.1 | 180.0 |
| Говьсүмбэр | 28,065.3 | 49,232.2 | 79,477.5 | 161.4 | 283.2 |

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тухайн хугацааны турш гадагш худалдсан бараа буюу үзүүлсэн ажил, үйлчилгээний хэмжээ байдаг. Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2018 онд 116112.3 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 56437.1 сая төгрөг буюу 94.6 хувиар өссөн байна.

ДҮГНЭЛТ

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагын зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан болно.

Аж үйлдвэрийн борлуулалт нь улсын дүнд эзлэх хувь 2014-2018 онуудад 0.1-1.9 хувь, бүсийн дүнд 1.1-8.9 хувь болж өсч байна. Үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн дэд салбараар нь ангилж үзвэл цахилгаан, хий, усан хангамжийн үйлдвэрлэл 4.0 хувь, уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 56.0 хувь, боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл 40.0 хувийг тус тус эзэлжээ.

Аж үйлдвэрийн салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын ажиллагчдын тоо өмнөх оноос 17.3 хувиар өссөн байна. Салбараар авч үзвэл өмнөх оноос цахилгаан хий, усан хангамжийн салбарын ажиллагчид 11.3 хувиар, олборлох салбарын ажиллагчид 3 дахин өсч, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо 13.3 хувиар буурсан байна.

2018 онд нийт 423234.8 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн байна. Барилга угсралт их засварын ажлын 4.8 хувь нь орон сууцны барилга, 16.5 хувь нь орон сууцны бус барилга, 77.8 хувь нь инженерийн барилга, байгууламж, 1.0 хувь нь их засварын ажил байна.

Барилгын нийт хөрөнгө оруулалтын 1.7 хувийг улсын төсвийн, 1.6 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Манай аймгийн хувьд Худалдааны салбар нь ажиллах хүчний зах зээлд томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг бөгөөд сүүлийн жилүүдэд ихээхэн өөрчлөлтүүд бий болж худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага тогтмол өсч жилд дунджаар 30 аж ахуйн нэгж байгууллага нэмэгдсэн байна.

Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн эзлэх хувь нь 2018 оны байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 37.0 хувийг эзэлж байна.

Худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдын тоо сүүлийн жилүүдэд жилд дунджаар 19 хүнээр нэмэгдэж, 95.5 хувь нь 1-9 ажиллагчидтай жижиг аж ахуйн нэгж, байгууллага байна. Энэ нь аж жижиглэн худалдаа, дэлгүүрийн чиглэлээр илүү үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой юм.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2018 онд 116112.3 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 56437.1 сая төгрөг буюу 94.6 хувиар өссөн байна.

Худалдааны салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал нь суурь мэдээлэл болох юм.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

1. www.1212.mn
2. www.dornogovi.nso.mn.
3. Дорноговь аймгийн Статистикийн эмхэтгэл 2018 онд

Хянасан: Статистикийн хэлтсийн дарга

Боловсруулсан: Ахлах мэргэжилтэн

Мэргэжилтэн

Мэргэжилтэн

Х.Өлзийсүрэн

Б.Цэрэндорж

А.Амарзаяа

Б.Энхцэцэг